



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/168

Арвайхээр сум

**Зардал хуваарилах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XV.1.1.75 дугаартай Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл (Өвөрхангай, Арвайхээр, Хархорин, Хужирт сум) төсөл арга хэмжээний Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн "Жагсаалт батлах тухай" 409 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл (Өвөрхангай, Арвайхээр, Хархорин, Хужирт сум)-д зарцуулах 4,739,000,000 (дөрвөн тэрбум долоон зуун гучин есөн сая) төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Идэрсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

8224 11 0352

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар  
сарын 04-ны өдрийн 1168 дугаар  
захирамжийн хавсралт



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН БАГЦАД БАТЛАГДСАН XV.1.1.75 ХУУЛИЙН ДУГААРТАЙ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГАД ЭРХ ШИЛЖСЭН СУМЫН ТӨВИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ШИНЭЧЛЭЛ (ӨВӨРХАНГАЙ,  
АРВАЙХЭЭР, ХАРХОРИН, ХУЖИРТ СУМ) ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Төслийн код	Хуулийн дугаар	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг (мянган төгрөг)	2024 онд санхүүжих дүн
1	УТ2402804331001	XV.1.1.75	Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл (Өвөрхангай, Арвайхээр сум)	2024	2026	1,752,100.0	480,000.0
2	УТ2402804331002	XV.1.1.75	Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл (Өвөрхангай, Хархорин сум)	2024	2026	1,516,000.0	461,700.0
3	УТ2402804331003	XV.1.1.75	Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл (Өвөрхангай, Хужирт сум)	2024	2026	1,470,900.0	480,000.0
Нийт дүн						4,739,000.0	1,421,700.0